

# ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.09.29

## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Монголбанк 2027 оноос инфляцыг 5%-д хүргэхээр зорьж байна.
- Банкнүүдын 1 хувьцаа эзэмшигчийн эзэмшил 20 хувиас ихгүй байх ёстой.
- GLMT-ийн хувьцаа ₮1,000-1,020 бүсэд хүчтэй дэмжлэгтэй харагдаж байна.
- ERDN идэвхтэй арилжаалагдсан хэвээр байгаа бөгөөд ханш нь ₮20,240 хүрлээ

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.2%	-0.71%	25.47%
MSE A	1.49%	-1.21%	20.27%
MSE B	0.26%	-0.21%	34.89%

2025/09/22 – 2025/09/26

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
ADB	826,732,073.25
ERDN	555,740,190.00
CUMN	512,909,055.53
INV	446,494,145.00
KHAN	324,083,778.00

2025/09/22 – 2025/09/26

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
MIK	16,850.00	29.62%
HSG	18,170.00	15.00%
ADL	398.08	13.74%
MNP	791.40	13.22%
MMX	3,889.00	7.79%

2025/09/22 – 2025/09/26

2025 он 09-р сарын 29

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

12,963

ТОП-20 индекс

49,059

MSE A

19,146

MSE B

14,635



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.8%

2025-08 сар

ГВУН(сая\$)

5,683.43

2025-08 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,594.00

2025-09-28

 Эдийн засгийн мэдээлэл

## БАНКНЫ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ МОНГОЛ БАНК МЭДЭГДЛЭЭ

Банкны тухай хуулиар системийн нөлөө бүхий банкуудын нэг хувьцаа эзэмшигчийн эзэмшил 20 хувиас хэтрэхгүй байхаар заасан бөгөөд уг зохицуулалтыг 2026 он гэхэд бүрэн хэрэгжүүлэх ёстой. Анх хууль батлахдаа 2024 оны эхний хагаст багтаан хэрэгжүүлэхээр тусгасан ч банкуудын хүсэлтээр хугацааг сунгасан байдаг.

Харин Монголбанкны зүгээс хуульд дахин өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна. Төв банкны ерөнхийлөгчийн хэлснээр, хувьцаа эзэмшлийн дээд хязгаарыг 20 хувь бус илүү өндөр түвшинд тогтоох хэрэгтэй. Учир нь олон улсын хөрөнгө оруулагчид 20 хувийн босгыг хэтэрхий доогуур гэж үзэж байгаа аж. Одоогоор зөвхөн системийн нөлөө бүхий 4 банкнаас Хас банк л энэ шаардлагыг биелүүлээд байгаа юм.



Голомт  
файнэншил групп  
77.19%



Эйч Эс  
Холдингс ХК  
40.99%

Таван Богд  
Холдингс ХХК  
22.78%



ГЛОБУЛЛ ИНВЕСТМЕНТ ЭНД  
ДЭВЭЛӨПМЕНТ ПТИ. ЛТД  
60.8%

ТИ ДИ БИ  
КАПИТАЛ ХХК  
29.69%

## ИНФЛЯЦЫГ 2027 ОНООС 5%-Д ХҮРГЭЖ БУУРУУЛАХЫГ ЗОРЬЖ БАЙНА

Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваатай ярилцсан ярилцлагыг хүргэж байна.

Монголбанк 2026 онд эдийн засгийн өсөлтийг ойролцоогоор 5.6 хувь байна гэж тооцож байна. Гэвч гадаад орчны тодорхойгүй байдал өндөр хэвээр байгаа бөгөөд тарифын асуудал бүрэн шийдэгдээгүй, томоохон эдийн засгуудын хоорондын хэлэлцээрүүд үргэлжилж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь олон улсын зах зээл дэх түүхий эдийн үнэ, эрэлт, санхүүжилтийн нөхцлөөр дамжин Монголын эдийн засагт шууд болон шууд бусаар нөлөөлөх юм.

Дотоодын хувьд өсөлтөд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс бий. Тухайлбал, өвөлжилтийн хүндрэл, хаврын тариалалтын үр дүнгээс хөдөө аж ахуйн салбар ихээхэн хамааралтай. Мөн мега төслүүдийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл чухал нөлөө үзүүлнэ. Иймээс гадаад, дотоод орчинд томоохон шок гарахгүй гэсэн суурь тооцооллын дагуу Монголын эдийн засаг ирэх онд 5–6 хувийн өсөлттэй байх боломжтой гэж үзэж байна.

Монголбанк 2027 оноос инфляцыг 5 хувийн голчтой, 3–7 хувийн хүрээнд тогтворжуулах зорилттой байна. Суурь тооцоогоор 2026 онд инфляц 6 орчим хувьтай, 2027 онд 5 хувь руу буурах боломжтой гэж үзэж байна. Гэвч улирлын шинжтэй хүчин зүйлс болох ургац хураалт, өвөлжилт, зуншлага инфляцад савлагаа үүсгэх эрсдэлтэй. Иймээс Монголбанк шат дараатайгаар инфляцыг бууруулж, эхний ээлжинд 2–3 жил 5 хувь орчимд тогтвортой барьсны дараа дараагийн алхмаар 4 хувь руу бууруулах зорилготой. Инфляцыг сууриар бууруулж байж л зээлийн хүү багасч, иргэдийн бодит орлого хамгаалагдана гэж үзэж байгаа тул Монголбанк хатуу зорилт тавин бодлогоо хэрэгжүүлж байна.



## Зах зээлийн мэдээлэл

### ТОП-20 ИНДЕКС ОН ГАРСНААС ХОЙШ 6.23% УНАЛАА


График 2. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

### ГОЛОМТ БАНК ХК MSE:GLMT

График 3. GLMT хувьцааны ханшийн график




GLMT-ийн хувьцаа ₮1,000–1,020 бүсэд хүчтэй дэмжлэгтэй харагдаж байгаа бөгөөд ханш энэ түвшинд ойртох тохиолдолд худалдан авах эрэлт эрчимжих төлөвтэй байна.

## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.